

Сүрьеэгийн лавлах лабораторт хийгдэж буй шинжилгээний төрөл

Шинжилгээний төрөл	Шинжлэгдэхүүн	Тодорхойлогдох үзүүлэлт
А. Нян судлалын шинжилгээ	1. Цэр	Циль-Нильсений аргаар хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээ
		Флюорохромын аргаар хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээ
		Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх
		Шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөх
		Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчин сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох
		Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчин сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох
	2. Шээс	Циль-Нильсений аргаар хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээ
		Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх
		Шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөх
3. Плеврийн шингэн	Циль-Нильсений аргаар хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээ	
	Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх	
	Шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөх	

Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

4. Өтгөн

Хүчилд тэсвэртэй нян (ХТН)

Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх

Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

5. Идээ

Хүчилд тэсвэртэй нян (ХТН)

Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх

Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

6. Мэс заслын материал

Хүчилд тэсвэртэй нян (ХТН)

Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх

Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

7. Нугасны ус

Циль-Нильсений аргаар хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээ

Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх
Шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөх
Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох
Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

8. Хэвлийн шингэн

Циль-Нильсений аргаар хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээ

Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх
Шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөх
Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох
Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

9. Үений шингэн

Циль-Нильсений аргаар хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээ

Хатуу тэжээлт орчинд өсгөвөрлөх
Шингэн тэжээлт орчинд өсгөвөрлөх
Ялгасан өсгөвөрт хатуу тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I, II эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох
Ялгасан өсгөвөрт шингэн тэжээлт орчинд сүрьеэгийн эсрэг I эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох

Б. Молекул биологийн шинжилгээ

Ялгасан өсгөвөр, түрхэц өндөр эерэг цэр

Сүрьеэгийн нян илрүүлэх
Сүрьеэгийн нян илрүүлэх
Сүрьеэгийн эмэнд дасалтай нян илрүүлэх

**В. Иммунолог
шинжилгээ**

Цусны ийлдсэнд

Эсрэг бие тодорхойлох

Аденозин деаминаза идэвхжил тодорхойлох


Интерферрон гамма концентраци тодорхойлох

**Плеврийн
шингэн, нугасны
ус, үений шингэн,
хэвлийн шингэн**

Аденозин деаминаза идэвхжил тодорхойлох

Интерферрон гамма концентраци тодорхойлох

Сүрьеэг оношлох нян судлалын шинжилгээний стандарт загвар



Түрхэцийн шинжилгээ

Өсгөврийн шинжилгээ

Эмэнд мэдрэг чанар
тодорхойлох

Цэрний шинжилгээ өгөх аргачлал

Цэрний шинжилгээ хийхийн ач холбогдол:

Цэрний түрхэцийн шинжилгээ нь сүрьеэг оношлох, эмчилгээний үр дүнг тодорхойлох хамгийн найдвартай арга юм. 1-р шинжилгээг үзүүлэхээр ирэх үед эмнэлгийн ажилтны заавар хяналтан дор авч лабораторид хүргүүлнэ.

2-р шинжилгээг та өөрөө авна. Зориулалтын саваа авч яваад өглөө босонгуут цэвэр усаар амаа зайлаад ханиалгаж цэрээ аваад таглаж лабораторид хүргэж өгнө. Хоёр удаагийн цэр зөв авсан тохиолдолд оношлогоо найдвартай болно.

Шинжилгээг ямар саванд хэдэн удаа өгдөг вэ?

Цэрний шинжилгээг тусгай зориулалтын эргэдэг тагтай саванд авна. Уг савыг эмнэлгийн байгууллага өгнө. Шинжилгээнд зайлшгүй 2 удаагийн цэр авна.

Зориулалтын саванд хэдий хэмжээний цэр авах вэ?

Савны сумаар заасан хэсэг хүртэлх хэмжээний цэрийг шинжилгээнд өгнө.

Шинжилгээг ямар нөхцөлд авах вэ?

Цэрийг гадаа гарч авах нь бусдад халдвар тараахгүй байх сайн талтай. Гадаа гарах боломжгүй хэвтрийн өвчтний шинжилгээг гэрт нь аль болох бусад хүмүүсээс тусгаарлаж аваад, агааржуулалт сайн хийх хэрэгтэй.

Шинжилгээний хариу хэдийд гарах вэ?

Шинжилгээний хариу 24 цагийн дотор гарна. Хариугаа үзүүлсэн эмчээс аваарай. Таны шинжилгээ зөвлөмжийн дагуу зөв авагдсан эсэхэд үнэлгээ өгөөрэй.

Шинжилгээг яаж зөв өгөх вэ?

Шинжилгээг өгөхийн өмнө амаа буцалгасан усаар зайлна.

Гүнзгий амьсгаа аваад цээжний гүнээс хахирч ханиалган цэрээ гаргана.

Гаргасан цэрээ шинжилгээний саванд нулимна.

Цэрний савны гадна талыг цэрээр бохирдуулж болохгүй.

Цэрний савны тагийг сайтар чанга таглана.

Рентген, флюор зургийн шинжилгээ, туберкулины сорил өгөхөд бэлтгэх онцгой зүйл байхгүй бөгөөд шинжилгээ хийгдэх хугацаанд өвчтөн өөрийн биеэр ирнэ. Туберкулины сорилын хариуг 48-72 цагийн дараа сорил хийсэн газарт үүссэн хариу урвалын өөрчлөлтийг хэмжиж тодорхойлдог бол рентген, флюор зургийн хариуг нарийн мэргэжлийн эмч уншилт хийж дүгнэлт гарган 24 цагийн дотор өгнө.